

142 ДАЙСНАА МЭД

142.1 ДАЙСНЫ ТӨЛӨВЛӨГӨӨГ МЭДЭЖ БАЙХ

Амьдралын эн тэргүүнд тавих зүйлсийг өөрчилдөг дайсны төлөвлөгөөг ялган таниж мэдэхгүйгээс болж олон итгэгч хүмүүс эргэлзэж, бүтэлгүйтсэн, бэрх замаар явдаг.

Тиймээс санаж зорьж, хийж бүтээж байгаа зүйл нь Бурханы үгийн дагуу байгаа эсэхийг шалгаарай.

Би амжилтанд хүрэхийн тулд Үгэнд захирагдан эсвэл өөрийн санаа, арга барил, туршлагыг дагаж хичээж байна уу?

Миний зорилго Христ дэхь мөнх амьдралын төлөө төвлөрсөн үү? Бурханы үггүйгээр үйлдэхийг дайсан турхирдаг. Амьдралаа Бурханы Үг дээр хэрхэн төлөвлөхийг суралц. Бурханы Үгийг зөв шалгаж, яагаад Бурхан бүх зүйлийг Бурханы Үгэнд суурил гэснийг ойлго.

142.2 САТАН ШҮҮЛТИЙН ҮГ РҮҮ ХӨТӨЛНӨ

Бурхан бидэнтэй нэг нэгээр нь хамт зохистой цагт нь ажилладаг. Түүний хаанчлалыг дэлхий дээр барихын тулд бүх эш үзүүлэлт цаг хугацаа, улирал байдаг. Тэр таны бэлдэж байсан алхмууд, хүлээн зөвшөөрөгдөх чанаруудыг ажиглаж байгаа бөгөөд энэ нь эд юмсын хэмжээ биш харин таны зүрх сэтгэл, хандлага юм.

Ерөөл гэдэг нь Түүний хангамж ба хамгаалалт дотор та байна гэсэн үг бөгөөд та Бурханы ерөөлийн суваг болдог.

Бурхан таны золиос зориулалтыг хүлээн авч, залбирлын аяга тань бялхах үед Бурханаас ирдэг ерөөлийн хаалга нь нээгддэг. Түүний амлалтын үг болон таны залбирлын дүүрэн аяга нь цаг хугацаа болсныг харуулах тэмдэг юм.

Нүглүүдийн аяга нь дүүрэн байвал (жишээ нь, Үер, Цамхаг Бабел, Содом, Гоморра, Египет, Вавилон, Ассири, Израиль ба Иуда, хорон муу субъект гэх мэт) хараал зүхэл ба шийтгэлүүд ирдэг.

Өнөөдөр ч, шүүлтийн эцсийн өдөр ч дэлхий дээр ивээл ч, хараал ч байх болдог.

Бурхан таныг ивээхийг хүсдэг, харин итгэлгүй байдлаас нь болж Бурханы Үг таныг хамгаалдаггүй бөгөөд та дайсанд урхидуулах болдог. Танд нүглийн аяга дүүрвэл дахин наманчлахыг анхааруулсан. Улс үндэстнүүдэд байгууллага, сүм хийд, хувь хүнд ч мөн адил хамаатай. Ерөөл эсвэл хараалын алийг хүртэх нь таны сонголт юм. Таны өнгөрсөн нь таны ирээдүйн гэрчлэл юм.

142.3 ДАЙСНЫ ХӨНӨӨХ, УСТГАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

- 1) Бурханы Үгийн эсрэг яв
- 2) Ариун сүнсний үйлсийн эсрэг яв
- 3) Бүх зүйлд эргэлзэж бай
- 4) Залбирлаа зогсоо
- 5) Үгийг сонсож, ойлгож чадахгүй
- 6) Итгэгчдийн дунд хагарал үүсгэх
- 7) Бурханы үгийг буруу ойлгох
- 8) Эн тэргүүнд тавих зүйлсээ хольж хутгаж, буулт хийх
- 9) Хувиа хичээсэн, өөрийгөө л голчилдог байх
- 10) Итгэл үнэмшлээр биш сэтгэл хөдлөлөөр шийдвэр гаргах

142.4 САТАНЫ ЗАЛЬ МЭХ (А)

Сатан итгэгчдийг хамт олноос салгахын тулд оюун ухааныг нь хутгалдуулж, ганцаараа ажиллахад хүргэдэг.

Сатан хүмүүсийн дунд хэрхэн ажилладгийг мэд. Сатан үргэлж ардуур ажилладаг. Сатан үл итгэгчид нөлөөлж анхаарлыг нь сарниулдаг

бөгөөд, соёлын зүйлс, хобби, боловсрол, хайр дурлал, шунал гэх мэт хэлбэрээр итгэгчдийг уруу татан Бурханы үйлийг саатуулдаг.

Эдгээр зүйлийн араас юу жолоодоод байгааг бид мэдэх ёстой.

Бурхан бидний юу хийж байгааг ажиглаж байдаг бөгөөд Сатан ч мөн ялгаагүй.

Сатан биднийг том зүйлээр сорьдог; Тэр том зүйлст нь уруу татагдахаас сэрэмжил.

Агаарын хүчний эсрэг яаж тэмцэх вэ?

Сатан болон муу сүнснүүдийн төлөвлөгөө

1. Ева, Адам хоёрт үйлдсэн шигээ уруу таталтын сүнснийг хүн бүрт илгээх.
2. Амьдралынхаа эн тэргүүнд тавих зүйлсийг бүрхэгдүүлж , шүтээн шүтэхэд хүргэх. Шунах нь шүтээнд мөргөж байгаа явдал юм.
3. Саулд өгөгдсөн шиг тарчлалын сүнс илгээх
4. Давидын санааг үймүүлсэн шиг шаардлагагүй зүйлийг хийхэд оюун санааг өдөөх.
5. Иовд хандсан шигээ сорилт, шалгалт хийх.
6. Бурханы үйлчлэгчдийн болон Түүний хүмүүсийн эсрэг босож Бурханаас таны амьдралд ирэх ерөөлийг хааж боох
7. Бурханы үгийг хүмүүсийн зүрх сэтгэлээс нь авч хаях
8. Хүмүүст гамшиг, өвчин эмгэгийг үүсгэх
9. Агаар дахь муу ёрын сүнснүүдийн хүч чадлаараа дэлхийг хянах
10. Хүмүүсийг амарч, залхуу болгоход жолоодох. Цагаа дэмий үрэх нь амралт, сэтгэл сэргээм зүйл биш ээ. Залхуурал хүмүүсийг төөрөлдүүлж,

ухралт хийлгэж, итгэл, үнэнийг орхиход хүргэнэ. Ингэж Бурхан, хүн хоёрын хоорондох харилцааг муутгадаг.

11. Бурханы хүүхдүүдийг улаан буудай мэт шигшихийг шаардах.

12. Сайн мэдээ дэлгэрүүлэх ажилд саад болох, зогсоох, эвдэх бүх аргыг хэрэглэх

Хаана байгаагаа шалгаад, Диаволын заль мэх хэрхэн даван түүлахаа мэдэх

142.5 САТАНЫ ЗАЛЬ МЭХ (Б)

1. Ариун Сүнсний чиглүүлгийг үгүйсгэж махан биеийн уруу таталт, шунал тачаалд автуулах

11Хайрт хүмүүс ээ, сэтгэлийн чинь эсрэг дайн хийдэг махан биеийн хүсэл тачаалуудыг цээрлэхийг харь хүмүүс болон түр хугацаагаар байгч та нараас би гуйя. (1 Петр 2:11)

2. Биеэ барихаа больж, дур зоргоороо авирлаж, садар самуунд урхидуулахад хүргэх

Аливаа хорсол, уур, хилэн, шуугиан, гүтгэлэг нь бүх бузар муугийн хамт та нараас зайлаг. Эфес 4:31" (Ефес 4:31 АБ 2004)

3. Биднийг бардам ,сагсуу байлгах

²⁰Мэргэн хүн хаана байна? Хуулийн багш хаана байна? Энэ үеийн маргалдагч хаана байна? Бурхан энэ ертөнцийн мэргэн ухааныг мунхаг болгоогүй гэж үү? (1 Коринт 1:20 АБ 2004)

4. Шүүлтийн Үгийн эсрэг чамайг уруу татах

"19 Эдүгээ махан биеийн үйлс нь илэрхий юм. Эдгээр нь завхайрал, бузар байдал, тачаангуй байдал, 20шүтээн шүтэх, ид шид, дайсагнал, маргаан, хардалт, уур хилэн, өрсөлдөөн, хагарал, тэрс үзэл санаа, 21атаархал, архидалт, утга учиргүй наргиж цэнгэх зэрэг нь юм. Би урьд

нь та нарт сануулж байсанчлан урьдчилан сануулъя. Ийм зүйлсийг үйлдэгчид нь Бурханы хаанчлалыг өвлөхгүй.(Галат 5:19-21 АБ 2004)

5. Үгийн эсрэг үйлдлийг зөвтгөх

28 Тэд Бурханыг хүлээн зөвшөөрөхөөс татгалзсан учраас Бурхан тэднийг завхарсан сэтгэлтэй нь зөнд нь орхиж, хийх ёсгүй зүйлсийг үйлдэхэд хүргэсэн бөгөөд 29 тэд бүхий л зөвт бус байдал, хорон муу, шунал, бузар булайгаар дүүрэн, атаа жетөө, аллага, хэрүүл, заль мэх, хар санаагаар дүүрэн, хов жив яригч, 30 гүтгэгч, Бурханыг үзэн ядагч, дээрэлхүү, их зантай, сагсуу, хорон мууг санаачлагч, эцэг эхдээ дуулгаваргүй, 31 ухваргүй, найдваргүй, үл хайрлагч, өршөөл үзүүлдэггүй хүмүүс ажээ. 32 Ийм зүйлсийг үйлдэгч нь үхвэл зохино гэсэн Бурханы зарлигийг тэд мэддэг хэрнээ өөрсдөө үйлдээд зогсохгүй, харин ч бусдыг үйлдэхэд нь сайшаадаг ажээ. (Ром 1:28-32 АБ 2004)

6. Шүүлтийн улам гүн нүгэлт зам руу уруу татагдан, бузартсан хоёр

нүүртэн болоход хүрэх мөн Бурхан тэднийг зөнд нь орхидог.

¹¹Бурууг үйлддэг нэгэн нь буруугаа үйлдсээр л байг. Бузар муу нэгэн нь бузар муу чигээрээ л байг. Зөвт нэгэн нь зөвт байдлаа хэрэгжүүлсээр л байг. Ариун нэгэн нь өөрийгөө ариунаар сахисаар л байг. (Илчлэлт 22:11 АБ 2004)

7 Хувиа хичээсэн үеийнхэн ба зовлон зүдгүүрийн цагийг авчрах 1Эцсийн өдрүүдэд хэцүү цаг ирнэ гэдгийг мэдэж ав. 2Учир нь хүмүүс өөрсдийгөө хайрлагчид, мөнгийг хайрлагчид, сагсуурагчид, их зантай, доромжлогчид, эцэг эхдээ захирагдахгүй, үл талархагч, ариун бус, 3үл хайрлагч, эвлэршгүй, гүжирдэгчид, биеэ хянадаггүй, хэрцгий, сайныг үзэн ядагчид, 4тэрслэгчид, бодлогогүй, биеэ тоодог, Бурханыг хайрлагчид байхаас илүү зугаа цэнгэлийг хайрлагчид болох болно. 5Тэд бурханлаг байдлын дүртэй байх боловч түүний хүчийг нь үгүйсгэдэг. Чи ийм хүмүүсээс зайлсхийж яв.(2 Тимот 3:1-5АБ 2004)

8. Үгээрээ дамжуулан байгаль орчин, хүмүүсийг бузарлах

1 Аманд орсон юм хүнийг бузарладаггүй, харин амнаас гарч буй нь хүнийг бузарладаг юм гэхэд (Мат 15:11 АБ 2004)

Хуурамч бурхад, эрх мэдлийг дагагчид хамтдаа явдаг. Эдгээр бурхадад гурван нийтлэг зүйл байдаг : миний хувьд, одоо. (ирээдүйд биш зөвхөн одоод үйлчлэх ба зөвхөн дэлхий дээр)

142.6 САТАНЫ ЭЦСИЙН БАЙР

Хөөгдсөн муу ёрын сүнснүүд хаашаа явах вэ? Тэд шүүлтийн эцсийн өдөр хүртэл ёроолгүй нүхэнд биш харин дэлхий дээр усгүй (үг) хуурай газар үлдэх гэж хайж байна . Сатаны хүч

эцэстээ нь алга болно.

Таны эргэн тойронд Антихристийн шинж тэмдэг

- 1) Хуурамч эш үзүүлэгчид гарч ирнэ
- 2) Хүйтэн хөндий болох
- 3) Гэрлийн сахиусан тэнгэр шиг ирдэг
- 4) Буруу сургаалыг заах
- 5) Нүгэлт үйлдлийг дэмжих
- 6) Сүмийн нөхөрлөлөөс тусгаарлах
- 7) Христийг хайрладаггүй
- 8) Эв нэгдэл бус хуваагдлыг бий болгодог
- 9) Сайн мэдээг түгээхийг зогсооно

142.7 БУРХАНЫ ҮЗЭН ЯДДАГ ЗҮЙЛИЙГ САТАН ХИЙЛГҮҮЛДЭГ

- 1) Бурханы нүгэл гэж үздэг зүйлийг зөвтгөх онол
- 2) Худал шүтээн дагах

- 3) Ихэмсэг харц
- 4) Худал ярих
- 5) Гэмгүй цус урсгасан гар
- 6) Бузар мууг сэтгэдэг
- 7) Бузар муу руу гүйдэг хөл
- 8) Хуурамч гэрч
- 9) Харилцаагаа муутгаж, зогсоох
- 10) Жигшсэн, хүлээн зөвшөөрөх боломжгүй ,бэлтгэлгүй золиос гаргах
- 11) Хүлээн зөвшөөрөгдөхгүй мөргөлийг өргөх
- 12) Итгэлгүй, төвөгшөөсөн, нулимстай мөргөлийг өргөх
- 13) Бурханлаг үр удмыг олж авч чадахгүй
- 14) Бусдын зүрхийг шархлуулж, гомдоох
- 15) Эзэнийг гутаан доромжлох
- 16) Бурханы эсрэг ярих; Зам болон Сайн мэдээ гомдоох
- 17) Гэмшлийг зогсоож, гэмшихгүй байх

Их Эзэний үзэн яддаг зүйлийг хийдэг хүмүүстэй бүү хамт бай;Бурханы зүрх сэтгэлийг бүү гомдоо.

142.8 САТАН ТАНЫ СЭТГЭЛИЙГ БУСНИУЛАХ ГЭЖ ЯАРДАГ

Итгэл нь зүрхэнд нахиалж, найдварыг бий болгож, эцэст нь болох зүйлийг бий болгодог. Энэ үйл явцад юу саад болдог вэ? Үгийн дагуу залбирч буй дагалдагчийн зүрх сэтгэлийг Сатан үймүүлдэг.Сатан хөндлөнгөөс нөлөөлөн хагарал үүсгэж, сүйрэлд хүргэж, таныг хуучин байсан байранд аваачыг хүсдэг.

Таны оюун санааг Сатан бусниулах үйл ажиллагааг хийх гэж дайран үр жимс ургуулахад(Бурханы алдрын төлөө) саад хийдэг. Цэргүүд нь ахмадынхаа найдварыг бусниулбал тулалдаанд юу болох вэ?

Та идэх,уух, бусадтай нийгэмшиж харилцахдаа хэнтэй хамтрах вэ?

Мөчрүүд нь үр жимс өгөхөд саад болж хэн таныг бусниулж байна вэ? Энэ бүхний цаана юу байна вэ?

142.9 ТАНЫГ САТАН ЯАРУУЛДАГ

Юу ч хийхдээ хянамгай бай. Таныг Сатан яаруулж сандруулж мөн амьдралыг нь бусниулдаг.

Болгоомжтой байгаарай! Өндөр барилга барьж байгаа юм шиг төлөвлөж, усан дээр том хот байгуул. Үгийн суурин дээр нэг нэгээр нь барина.

Хариулт нь Дуулал Нэгдүгээр бүлэгт байдаг. Ямар ч жимс байсан Үгэн дээр суурилагүй л бол дэмий хоосон гэсэн үг. Бүх шаргуу хөдөлмөр нь цаг хугацаа өнгөрөхөд дэмий үрэгддэг, мөн цаг хугацаа алдсаны төлөө та хариуцлага хүлээнэ.

Таны ажил шуналаас үүдэлтэй юу? Шунал сэтгэлийн түгшүүр төрүүлж, бусдыг гомдоож, улмаар нүгэлтний замд хүргэдэг. Та юу ч хийсэн туршлага эсвэл хүний зөвлөгөөн дээр биш Үг дээр суурил. Эс тэгвээс таны ажил цаг хугацааны эрхээр нуран унах болно.

Залруулга, чиглүүлэхийн тулд Бурханы бичигдсэн үгнээс эш үзүүллэг өгөгддөг.

142.10 САТАН ӨВЧНИЙГ ЗӨВХӨН ТҮР ЗУУР ЭМЧИЛДЭГ

Өвчний үндсэн шалтгааныг эмчилж, бүр мөсөн эдгэрээгүй л бол өвчтөн дахин өвдөх болно.Бид үндсэн шалтгааныг засахгүй л бол асуудал эргэж үүсдэг.

Та эдгэрэлтийг Бурханаас уу эсвэл Сатанаас хүлээн авдаг уу?

Та Бурханы сэтгэлд нийцсэн, Түүний зүрх сэтгэлд илүү ойр байдаг зүйлийг хийдэг үү?

Сатан таныг ганцаараа ажиллахыг хүсдэг. Тэр яагаад ганцаараа ажиллах ёстой талаар тайлбарлаж, шалтаглуулахдаг. Сатан бол таны амьдралд нөлөөлөхийг хичээдэг жинхэнэ сүнслэг биет юм. Таны амьдралыг сүйтгэж, ахиц дэвшилд чинь саад болно.

Сатан дайрахаа зогсоохгүй. Та Сатан ба муу ёрын сүнснүүдийг ялах ёстой.

142.11 САТАН ЮУНААС Ч АЙХГҮЙ, ЗӨВХӨН ҮГНЭЭС

Сатан дэлхий дээрх юунаас ч айдаггүй; тэр Их Эзэний амнаас гарсан үгнээс л айдаг.

Яагаад тэр үү? Бурханы оршихуй байгаа газар Сатан байж чадахгүй боловч хаалгаа нээсэн хүмүүсийн оюун ухаан, зүрх сэтгэлд хавчуулагдан нуугдддаг.

Таны бие бол Бурханы сүм; Энэ нь ямар утгатай вэ? Миний нэрээр хоёр гурвуулаа цуглардаг газар би дунд нь байна. Энэ юу гэсэн утгатай вэ? Хэрэв та урихгүй бол Бурханы сүмд Сатан орж чадахгүй.

Таны зүрх сэтгэлээс Үгийг хулгайлж, эргэлзэхэд хүргэж, мэдрэмжгүй байлгаж эсвэл саад болохын тулд Сатан юу ч хийх болно. Сатаны айдаг цорын ганц зүйл бол Үг. Үгийн оршихуй нь түүний нөлөө ба хүчинд саад болдог. Тиймээс Үгийг дотроо хадгал. Итгэлтэйгээ хослуулж Үгийг хүлээн зөвшөөрч, тунхаглаж, ойлгож итгэ. Үгийг дагаж дайснаа хөлийн гишгүүр болгодог, Өглөөний шүүдэр” “багийн баяр хөөртэй сайн дурын ажилтан бол.

Диавол хурдан ухрахгүй. Бид залбирлаараа диаволын заль мэхийг зогсоох ёстой. Ялалт ирэх хүртэл итгэлээр эсэргүүцэн зогс. Үг яриа, үйлдэл, ухамсартаа диаволд боломж бүү өг. Гэмшилд түргэн бай; Их Эзэнийг үргэлж урьж өөрийгөө хэн болох, Түүнийг хэн болохыг хүлээн зөвшөөр. Соргог байж Сүнс юу хэлж байгааг сонс. Бүхий л санаа

зовниолоо Их Эзэнд даатга. Түүний Үгийн бат бөх суурь дээр хатуу зогсвол Түүнийг алдаршуулах ялалт ирнэ.

ТҮҮНИЙ ОРШИХУЙ БИДНИЙ ХАМТ БАЙХГҮЙ ҮЕД БИД ТУЛААНДАА ЯЛАХГҮЙ. ИТГЭХГҮЙ ҮЕД ЗАЛБИРЛЫН ХАРИУ ИРЭХГҮЙ. ТЭР ХЭЛСЭНЧЛЭН ТЭР БАЙНА ГЭДЭГТ ИТГЭН ЭРГЭЛЗЭЛГҮЙ ЗАЛБИР.

142.12 САТАН ШУРГАЛАН ОРЖ ИРДЭГ

Сатан Искарриотын Иудасын чихэнд шивнэв. Тэр Есүс Христэд дагалдагчаар үйлчилж байсан нэгэн боловч үл итгэгч, бузар зүрхтэй байсан учраас Сатан үүнийг ашиглан эргэлзүүлж, Иудагийн оюун санаанд вирус шиг хөнөөх хуйвалдааны төлөвлөгөөг бий болгосон.

Зүрх сэтгэлээсээ гүн гүнзгий, шимширсэн гэмшлээр зүрх сэтгэлийн талбайгаа хагалаарай. Зөвхөн Христ л өгдөг амар амгаланг зүрх сэтгэл дотроо ол. Ус болох Үгээр таны зүрх сэтгэл цэвэрлэгдэнэ. Үг гэж юу болох, Христ гэж хэн бэ гэдгийг бод. Христ дэлхийд юуг өгсөн бэ? Амар амгаланг уу эсвэл сайн сайхан байдлыг уу? Эсвэл буруу байгаа зүйлийг нэвтэлдэг Үгийг үү?

142.13 САТАНЫ ЭСРЭГ ХЭРХЭН ЯЛАХ ВЭ?

1. Үг ба итгэлээр ял: Дэлхийн алдар нэр биш, Харин Үг болох Еховагийн хүч. Бид Үгийн хүчийг эзэмших ёстой (Матай 4:4-7)
2. Арга заль, ноу-хау эсвэл туршлагаар бус харин Ариун Сүнсний хүчээр. (Матай 12:8/ Иаков 4:7)
3. Дайсны төлөвлөгөөг залбирал ба эсэргүүцлээр хааж ялах
4. Бурханы бүх хуяг дуулга өмсөж ял. (Ефес 6:11)
5. Залбирлын хүчээр ял. Бурханыг хөдөлгөх залбирлын төлөө элч Паул гуйсан.
6. Дайсандаа боломж олгохгүй байж ялна. (Ефес 4:25-27)
7. Ариун Сүнсний дүү хоолойг сонсож үргэлж ял (1 Петр 5:7-8)

8. Бүх санаа зовнилоо Эзэнд зориулснаар ял. (Дуулал 37:5)

Христ таныг ажиглаж байна. Тиймээс тууштай зогс. Бурханы нигүүлслээр бат зогсож дайснаас бүү ай, мөн ялалт байгуул.

Бурханы танд үзүүлсэн зүйлийг тунхагла. Таныг ажиллахаа больсон үед Сатан хайрладаг. Бүү ай. Бурхан илгээнэ. Түүний хэлсэн зүйлийг биелүүлдэг хүмүүсийг Бурхан илгээнэ. Тэр бол амьд бурхан; Тэр удахгүй ирнэ. Түүний үгсэд бүү хайнга бай. Үгийг нь дагаж, уншиж, Түүний Үгэнд итгэж, хэрэгжүүлдэг хүмүүст Бурхан хайртай.

142.14 САТАНЫ ДУУ ХООЛОЙГ БҮҮ ДАГААРАЙ

Хэрэв таны туршлага, мэдлэг Ариун Сүнсний ажилд саад болж байвал болгоомжтой байгаарай. Хэрэв та даалгавраа биелүүлж байхдаа Түүний алдрыг өөртөө авч буй бол сонор сэрэмжтэй байгаарай. Чиглэлүүд нь Ариун Сүнс, өөр сүнснээс эсвэл хоёулангаас нь байгаа эсэхийг анзаарч мэдээрэй. Хэрэв та Хоньчны дууг сонсвол сайн зарц ба хөлсний хүн хоёрын хоорондын ялгааг мэднэ. Хоньд нь хоньчныхоо дууг сонсдог.

Асуулт асуу: та хэний дуу хоолойг сонсож, дагаж байна вэ?

Та хөлсний хүн үү? Та хэний төлөө ажилладаг вэ? Их Эзэн ингэж асуусан уу? Үгэн доторх зааварчилгыг дагадаг уу? Энэ нь зөвшөөрөгдсөн үү? Галын шүүлтийн өдөр үнс болон хувирахгүй байх зүйлийг та золиосолсон уу? Их эзэний дуу хоолойны дагуу барьж байна уу? Барилгын Архитектор-дизайнер бол Эзэн бөгөөд та бол барилгын багийн гишүүн юм. .

Шүүлтийн цагийг бүтээгч Бурханаас өөр хэн ч мэдэхгүй. Тиймээс Шүүлтийн өдрийг мэддэг үздэг хүмүүсийн тунхагласан эш үзүүлэгүүдийг сонсох хэрэггүй

142.15 ТА ХЭНИЙГ БАЯРЛУУЛДАГ ВЭ?

Хагалан бутаргахад оролцох нь Сатанд таалагдаж,

Эв нэгдэлд оролцох нь Бурханд таалагддаг.

Үзэн ядалтаар дүүрэн жолоодлого нь Сатанд таалагдаж,

Хайраар дүүрэн хүсэл нь Бурханд таалагддаг

Бусдад бүдүүлэг, ёс суртахуунгүй ханддаг авир Сатанд таалагдаж,

Бусдад хүндэтгэсэн, анхаарал тавин хандах нь Бурханд таалагддаг,

Ихэмсэг, бардам сүнс Сатанд таалагддаг.

Даруу, гэмшсэн сүнс Бурханд таалагддаг.

Махан биеийн хүсэл тачаал, хүслийн араас хөөцөлдөх оюун ухаан ба Сүнсний эсрэг Сатаныг баярлуулж,

Амин хувиа хичээж, өөрийн ажилдаа санаа тавих нь зөвхөн Сатанд таалагддаг.

Сүнслэг үнэт зүйлсийг мэдэх, сахиж дуулгавартай байх нь Бурханд таалагддаг.

Сайн дүр эсгэж, хоёр нүүр гаргах хандлага Сатанд таалагддаг.

Зориулалт гаргасан, тэсвэр хатуужилтай оюун ухаан нь Бурханыг баярлуулдаг.

Сайн мэдээг хүлээн авсан ч өөрийн тав тухыг бодож, Үгэнд эргэлзэх, сайн мэдээг хуваалцахдаа ичдэг байх нь Сатанд таалагддаг.

Улирлаас үл хамааран сайныг тариалах нь Бурханд тааламжтай байдаг.

Сайн мэдээг хойч үедээ дамжуулахгүйгээр өөрөөрөө л дуусгавар болгох нь Сатанд таалагддаг. Дараа үеийнхэний хүүхдүүдэд сайн мэдээг өвлүүлэх нь Бурханыг баярлуулж,

Бурханы ажлыг зогсоох нь Сатанд таалагдаж, Бузар мууг зогсоож, наманчлах; зөвийг үйлдэж сурах нь Бурханд таалагддаг.

142.16 БИ ХЭНД ТААЛАГДАЖ БАЙНА ВЭ? ҮР ДҮН?

Бурхан таны хүсэл эрмэлзэл, үйлдлийг хэмждэг. Түүнээс ерөөлийг хүлээн ав. Хүссэн зүйлээ биш харин Ехова Бурхан зүрх сэтгэлд тань оруулсан зүйлийг биелүүлэх хүсэл эрмэлзэлтэй байх. Залбирлаараа Түүн рүү ирж итгэлтэй залбирал нь хариулт авчирдаг гэдгийг мэдээрэй. Өөрийн хүсэлд тулгуурлан суурийг бий болгох нь элсэн дээр барихтай адилхан юм. Үр дүн нь тулаан, сүйрэл, дуулиан, аллага, салалт, бүтэлгүйтэл, үхэл болно

Дуулал 1 нь танд хийж болох хоёр замыг зааж өгдөг алийг нь ч сонгосон тус бүрдээ хувь тавилантай. Бурханы Үг дээр ажлаа тулгуурлаагүй бол дэмий хоосон , бүтэлгүйтэл л байх юм. Таны бүх шаргуу хөдөлмөр бол цаг хугацааг дэмий хоосон өнгөөрөөж үр дүн төгсгөлд нь Бурханы цаг үрсэнийхээ төлөөх нүглийн шийтгэлийг төлөх болно.

Та зүрхнийхээ шунал хүслийг дагаж байна уу?

Шунал нь сэтгэлийн түгшүүр, урам хугарал, зовлонг авчирдаг ба бусад хүмүүсийг гомдоодог. Гэхдээ нөгөө талаас ерөөлийн үр жимс нь Их Эзэнийг алдаршуулж, сэтгэл ханамжийг авчирдаг.

АНХААРУУЛГА: Таны үйлдлийг Бурхан болон бусад хүмүүс хардаг.

Ухамсрын тайван байдал нь таны хаана байгааг илтгэдэг.

Дэлхийтэй нийлэх нь зөвхөн назгайрал, саатал ба үрхинд хүргэдэг

Нүгэлд бүү авт, бүү дайснууддаа боломж бүү өг.

142.17 ШАШИН, ГАЖ УРСГАЛ

Үггүйгээр сонссон зүйлээ дагадаг хүмүүс төөрөгдүүлсэн шүтлэгтэй төстэй бичвэрүүдийг бичих болно. Хөлсний хүмүүс нь алдар нэрээ гайхуулах ба бусдад танигдахыг эрмэлзэх ба хүмүүсийн таалалд нийцүүлэхийн тулд Бурханаас сонссон зүйлээ ашиглана.

Эхлээд Үгийн мэдлэг дээр тулгуурлан, дараа нь Үгнээс Ариун Сүнсний дуу хоолойг сонсох ба залбирал нь зөв хоньчин болгоно.

Үгийг судал. Үг ба залбирлаар Ариун Сүнсний андууршгүй хоолойг сонсоорой.

Энэ нь Эзэн дотор нэг болж буйг харуулна. Нэг байхын тулд та бүгд Ариун Сүнсний дүү хоолойг сонсох ёстой; Тэрхүү нэг байдал нь зөв зам дээр байна гэсэн баталгаа өгөх болно. Ариун Гурвалын хүч илрэх болно.

Хөлсний хоньчин ба хуурамч эш үзүүлэгч болохыг олж мэд.

Тэдний үндсэн зорилго нь дараах зүйлийг хайж авах сонирхолтой байна уу?

- Мөнгө
- Алдар нэр
- Дарангуйлан удирдах
- Хувийн ашиг сонирхлын төлөөх зүйлс
- Мэдрэмжээ биелүүлэх

Тэд дараах зүйлийг хийж байна уу?:

- Христийн дахин ирэлтийн цаг эсвэл огноог тогтоох
- Тансаг амьдралын хэв маягаар амьдрах
- Зааж сургадаг шигээ амьдрахгүй
- Ёс суртахуунгүй эсвэл гэмшдэггүй
- Биелэгдээгүй эш үзүүлэгчүүдийг эш үзүүлэх
- Бурханы Үгээс илүү эш үзүүлэгийг чухалчлах
- Өөрсдийнх нь л үнэн гэж зарлах
- Бардам, ихэмсэг
- Шуналтай